

ДОТООДЫН

**ЗАХ ЗЭЭЛИЙН ДОЛОО
ХОНОГИЙН ТОЙМ**



2025.03.17

Дотоодын зах зээлийн онцлох мэдээ

ТОВЧ

- Төсвийн тэнцэл эхний 2 сард алдагдалтай гарлаа
- Шинжээчдийн 2025 оны макро эдийн засгийн төсөөлөл
- Дотоодын хувьцаанд хэзээ хөрөнгө оруулах вэ? (зөв стратеги)
- Компаниудын хувьцаа эзэмшигчдийн хурлын зар

МХБ-ийн индексийн өгөөж

Индекс	Долоо хоног	Сар	Жил
ТОП 20	-1.91%	2.05%	25.47%
MSE A	-1.12%	1.95%	20.27%
MSE B	-0.59%	3.99%	34.89%
2025/03/10 – 2025/03/14			

Идэвхтэй арилжаалагдсан үнэт цаас

Симбол	Үнийн дүн
KHAN	826,283,784.00
ADB	526,696,893.80
TGI	380,086,949.47
MSE	359,139,859.68
TTL	197,623,100.00
2025/03/10 – 2025/03/14	

Өндөр өсөлттэй үнэт цаас

Симбол	Хаалтын ханш	Өсөлт %
ERS	21,000.00	25.67%
HSR	2,530.00	15.00%
GTJ	1,150.00	15.00%
SOR	4,800.00	14.29%
ATR	38,600.00	13.86%
2025/03/10 – 2025/03/14		

2025 он 03-р сарын 17

Зах зээлийн
үнэлгээ тэрбум ₮

13,273

ТОП-20 индекс

51,215

MSE A

20,097

MSE B

15,060



МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

ДНБ өсөлт

4.9%

2024 он

Инфляц

9.6%

2025-02 сар

ГВУН(сая\$)

4,763.40

2025-02 сар

Бодлогын

хүү

12.0%

ЗГ-ын бондын
өгөөж

6.92%

USD/MNT

3,470.86

2025-03-16




Эдийн засгийн мэдээлэл

ТӨСВИЙН ТЭНЦЭЛ ЭХНИЙ 2 САРД ₮565.8 ТЭРБУМЫН АЛДАГДАЛТАЙ ГАРЛАА




Оны эхний хоёр сарын байдлаар улсын нэгдсэн төсөв 565.8 тэрбум төгрөгийн алдагдалтай гарлаа. Төсвийн нийт орлого, тусламж 4.1 их наяд төгрөгт хүрсэн нь өнгөрсөн оны мөн үеэс 22.9 хувиар буурсан үзүүлэлт болов. Харин нийт зарлага, цэвэр зээл 4.6 их наяд төгрөг болж, 22.1 хувиар өсжээ.

Сангийн сайдын мэдээлснээр, төсвийн орлого өмнөх оноос буурсан ч жилийн төлөвлөгөөний 11 хувийг бүрдүүлээд байна. Харин төсвийн алдагдал ДНБ-ий 3% буюу түүнээс дээш хүрсэн тохиолдолд төсөвт тодотгол хийх шаардлага үүсэх бөгөөд энэ босго 3 их наяд төгрөгт ойртож байгаа аж.



ШИНЖЭЭЧДИЙН 2025 ОНЫ МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ТӨСӨӨЛӨЛ

Монгол Банк 2025 оны 2-р сарын 17-27-ний өдрүүдийн хооронд банкуудын эдийн засагчид, их дээд сургуулиудын багш нар, судалгааны болон үнэт цаасны компаниудын нийт 25 шинжээчийн дунд макро эдийн засгийн төсөөллийн судалгааг явуулжээ.



2025 оны IV улиралд

- Инфляц 9.7%
- Эдийн засгийн өсөлт хурдасч 5.4%
- Зээлийн хүү өнөөгийн түвшинд 17.0%

2025 оны I улиралд

- Инфляц 10.1%
- Эдийн засгийн өсөлт өнөөгийн түвшинд 4.9%
- Зээлийн хүү өнөөгийн түвшинд 16.9%



Дотоодын зах зээлийн мэдээлэл

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ЗАР



Компанийн тухай хуульд заасны дагуу хувьцаат компани (ХК)-ууд Хувьцаа эзэмшигчдийн хурал (ХЭХ)-аа санхүүгийн жил дууссанаас хойш дөрвөн сарын дотор буюу дөрөвдүгээр сарын 30-наас өмнө зарлан хуралдуулах ёстой байдаг.

СҮҮ ХК

“Сүү” ХК-ийн 2025 оны хувьцаа эзэмшигчдийн хурал 04 сарын 22-ны 15:00 цагт “Холидэй Инн” зочид буудлын хурлын танхимд болно. Хуралд дараах асуудлууд хэлэлцэгдэнэ: 2024 оны санхүүгийн тайланг батлах, компанийн дүрэмд өөрчлөлт оруулах, Төлөөлөн Удирдах Зөвлөлийн бүрэлдэхүүн, цалин урамшууллын талаар шийдвэр гаргах, ногдол ашиг тараах асуудал. Хурлын бүртгэлийн өдөр 03 сарын 28-ны өдөр.

ХААН БАНК ХК

“ХААН Банк” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хурал 2025 оны 4-р сарын 24-ний 14:00 цагт Сүхбаатар дүүрэг, Сөүлийн гудамж-25, ХААН театрт болно. Хуралд 2024 оны үйл ажиллагаа, санхүүгийн тайлан, ногдол ашиг тараах, чанаргүй зээлийг хаах, аудитын тайлан, ТУЗ-ийн ажлын тайлан болон 2025 оны зардлын төсөв, хувьцаа эзэмшигчдийн бүтэц, хөрөнгийн өөрчлөлт зэрэг асуудлууд хэлэлцэгдэнэ. Хурлын бүртгэлийн өдөр 4-р сарын 4.

ГОЛОМТ БАНК ХК

Голомт Банк ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хурал 2025 оны 4-р сарын 17-ны 09:00 цагт Шангри-Ла зочид буудлын хурлын их танхимд болно. Хуралд 2024 оны үйл ажиллагаа, санхүүгийн тайлан, ногдол ашиг хуваарилах, ТУЗ-ийн ажлын тайлан, цалингийн төсөв, Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох, хувьцааны тоо нэмэгдүүлэх, дүрэмд өөрчлөлт оруулах асуудлууд хэлэлцэгдэнэ. Хурлын бүртгэлийн өдөр 3-р сарын 26.

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ ХК


“Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хурал 2025 оны 4-р сарын 21-ний 10:00 цагт тус биржийн төв байранд болно. Хуралд 2024 оны санхүүгийн тайлан, 2025 оны эдийн засгийн үзүүлэлт, системийн асуудлууд, Төлөөлөн удирдах зөвлөлийн цалин, хөлс, хяналтын зөвлөлийн гишүүдийг сонгох асуудлууд хэлэлцэгдэнэ. Хурлын бүртгэлийн өдөр 3-р сарын 31.

ДОТООДЫН ХУВЬЦААНД ХЭЗЭЭ ХӨРӨНГӨ ОРУУЛАХ ВЭ?

ТОП-20 индексийн хэлбэлзэл (2015-2025)

	2015	2016	2017	2018	2019	2020	2021	2022	2023	2024	2025	ДУНДАЖ
1 сар	-2.10%	-1.00%	5.40%	-4.20%	7.50%	0.90%	10.50%	1.90%	3.50%	7.00%	2.90%	2.90%
2 сар	-3.50%	-3.00%	-0.90%	-0.10%	-0.60%	-0.90%	29.20%	-4.60%	2.40%	5.50%	1.70%	2.30%
3 сар	-3.50%	-5.10%	4.60%	-1.00%	-2.60%	-4.00%	31.20%	-6.10%	0.50%	1.90%		1.60%
4 сар	-3.00%	-1.50%	2.50%	-4.60%	-3.70%	-8.70%	4.10%	-0.90%	-5.20%	-3.30%		-2.40%
5 сар	-2.40%	-1.20%	-1.60%	-2.00%	0.30%	-2.10%	1.20%	-6.70%	0.50%	-0.40%		-1.40%
6 сар	13.90%	5.20%	-1.60%	0.90%	-1.80%	-1.00%	-7.70%	-3.70%	-0.60%	0.80%		0.50%
7 сар	-2.60%	10.80%	8.20%	-1.00%	3.60%	2.00%	-1.10%	-0.80%	1.10%	9.80%		3.00%
8 сар	-6.70%	-1.80%	8.70%	-0.90%	-2.80%	1.60%	7.70%	4.60%	0.00%	3.50%		1.40%
9 сар	-0.40%	-7.40%	16.60%	3.50%	-3.20%	2.70%	27.50%	-1.50%	-5.40%	-1.30%		3.10%
10 сар	-0.60%	-2.70%	16.90%	2.10%	-3.60%	1.60%	-10.00%	-1.90%	0.60%	0.20%		0.30%
11 сар	-2.90%	-3.40%	9.30%	-2.00%	0.00%	0.50%	-2.40%	1.10%	4.60%	1.80%		0.70%
12 сар	-3.60%	7.00%	0.10%	0.10%	1.90%	3.30%	5.80%	5.40%	5.00%	2.00%		2.70%

ТОП-20 индексийн сарын дундаж хэлбэлзэл (2015-2020)



Монголын ТОП-20 индексийн дундаж хэлбэлзлээс харахад 1-3 сар, 7-9 сар, 12 саруудад өсөлт давамгайлдаг байна.

Ямар стратеги баримтлах вэ?

- Ногдол ашиг хүртэхийг зорьж буй бол 1-3 сард хувьцаа худалдаж авах нь тохиромжтой.
- Хямд үнээр хувьцаа авах боломж хайж байгаа бол 4-5 сард зах зээлийн уналтыг ашиглах хэрэгтэй.
- 7-9 сард зах зээл өсөх магадлалтай тул эрт худалдан авч, өсөлтийг ашиглах боломжтой.
- Жилийн эцэст (12-р сар) дунд хугацааны өсөлт ажиглагдах хандлагатай тул урт хугацааны хөрөнгө оруулалтад тохиромжтой үе.

НОГДОЛ АШГИЙН МЭДЭЭЛЭЛ

№	Компанийн нэр	Симбол	Бүртгэх өдөр	Нэгж хувьцаанд ногдох ашгийн хэмжээ
1	Дархан нэхий ХК	NEH	2025-03-10	0.226
2	Багануур ХК	BAN		23.62
3	Барилга корпораци ХК	BRC	2025-03-11	100
4	Хас Банк	XAC		27
5	Төрийн Банк ХК	SBM		63.70
6	Хаан банк ХК	KHAN		195.35
7	Материалимпекс ХК	MIE		150
8	Инвескор ББСБ ХК	INV		60
9	Айтүүлс ХК	ITLS		3.5
10	Мандал Даатгал ХК	MNDL		8.10
11	Улаанбаатар хивс ХК	UBH	2025-03-15	2000
12	Голомт Банк ХК	GLMT	2025-03-22	100
13	Сүү ХК	SUU		3.43
14	Таван толгой ХК	TTL		6960
15	Эм Жи Эл Акуа ХК	MGLA	2025-02-25	7.31
16	Гутал ХК	GTL	2025-03-31	2470
17	АПУ ХК	APU		65
18	Инновэйшн инвестмент ХК	QPAY		20
19	Монложистикс Холдинг ХК	MLG		5.4
20	Талх чихэр ХК	TCK		450
21	Би ди сек ХК	BDS		89.67
22	Сэндли ББСБ ХК	SEND	2025-03-15	7.61
23	Монгол Базальт ХК	MBW		2.42
24	Баянгол зочид буудал ХК	BNG		330
25	Тэнгэр Даатгал ХК	TGI		67.12
26	Монос хүнс ХК	MFC	2025-03-12	4
27	Газар Шим Үйлдвэр ХК	GAZR	2025-03-10	2.6
28	Улаанбаатар БУК ХК	BUK		10
29	Хүрд ХК	HRD		8
30	Тандэм инвэст ББСБ ХК	TAND		1.1
31	Бодь Даатгал ХК	BODI		5
32	Махимпекс ХК	MMX		100
33	Монгол шуудан ХК	MNP		1
34	Монголын хөрөнгийн бирж ХК	MSE		47
35	Гермес центр ХК	HRM	2025-03-07	9.60
36	ЛэндМН ББСБ ХК	LEND	2025-02-26	15
37	Эрдэнэт Суврага ХК	SVR	2025-02-26	5

T+2 төлбөрийн тооцооны системийн дагуу явдаг учир бүртгэлийн өдрөөс 2 өдрийн өмнөх эзэмшлээс тооцдог болохы анхаарна уу